

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/164/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2026 оны 02 дугаар сарын 24

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Г.Энхзул
Утас: 99333147 Цахим хаяг: enkhzulg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 2/57

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

6426050170

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	197,172,273.98	120,852,029.97
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	97,308,761.96	5,011,685.23
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	97,308,761.96	5,011,685.23
3121	Төгрөг	97,308,761.96	5,011,685.23
31211	Төрийн сангийн харилцах	97,308,761.96	5,011,685.23
35	БАРАА МАТЕРИАЛ	99,863,512.02	115,840,344.74
351	Түүхий эд материал	32,709,404.02	41,519,456.74
35110	Тусгай зориулалттай материал	32,180,864.02	40,898,166.74
35130	Эм боох материал	528,540.00	621,290.00
354	Хангамжийн материал	67,154,108.00	74,320,888.00
35410	Бичиг хэргийн материал	2,860,610.00	4,037,610.00
35420	Аж ахуйн материал	15,926,900.00	18,739,680.00
35470	Бусад хангамжийн материал	48,366,598.00	51,543,598.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,904,713,984.26	7,514,062,437.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,904,713,984.26	7,514,062,437.23
392	Биет хөрөнгө	6,669,721,667.58	7,279,070,120.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,156,808,923.00	7,017,714,713.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(132,358,836.26)	(321,062,897.42)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,000,000.00	30,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,249,999.96)	(10,250,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	407,552,360.00	443,223,652.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(108,327,884.21)	(180,679,643.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	352,609,555.97	372,598,855.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	(58,351,127.62)	(94,716,216.39)
39214	Бусад үндсэн хөрөнгө	27,970,200.00	27,970,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,931,523.34)	(5,728,543.34)
393	Биет бус хөрөнгө	234,992,316.68	234,992,316.68
39301	Програм хангамж	3,750,000.00	3,750,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	234,311,000.00	234,311,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(3,068,683.32)	(3,068,683.32)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,101,886,258.24	7,634,914,467.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	68,854,292.75	58,301,200.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	68,854,292.75	58,301,200.00
413	Өглөг	68,854,292.75	58,301,200.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	15,802,700.00
4136	Бусад өглөг	68,854,292.75	42,498,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	68,854,292.75	42,498,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,033,031,965.49	7,576,613,267.20
51	Засгийн газрын хувь оролцоо	7,033,031,965.49	7,576,613,267.20
512	Хуримтлагдсан үр дүн	7,033,031,965.49	7,576,613,267.20
51210	Өмнөх үеийн үр дүн	7,033,031,965.49	7,033,031,965.49
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	543,581,301.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,101,886,258.24	7,634,914,467.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,385,908,397.62	4,634,247,535.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	275,029,397.62	928,753,535.22
120	Нийтлэг татварын бус орлого	275,029,397.62	928,753,535.22

Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	30,006,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	30,006,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,110,879,000.00	3,705,494,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,559,916,100.00	3,138,329,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,559,916,100.00	3,138,329,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	550,962,900.00	567,165,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	550,962,900.00	567,165,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,219,303,529.65	4,087,166,233.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,219,303,529.65	4,087,166,233.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,120,094,996.02	3,956,398,601.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,912,580,999.71	2,479,067,630.11
210101	Үндсэн цалин	1,816,631,042.71	1,579,372,744.01
210102	Нэмэгдэл	95,949,957.00	723,737,026.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	9,460,000.00
210104	Урамшуулал	00.00	166,497,860.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	239,182,078.08	309,936,586.86
210201	Тэтгэврийн даатгал	164,688,896.76	210,499,122.64
210202	Тэтгэмжийн даатгал	17,171,200.58	24,868,394.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,025,945.30	12,434,197.30
210204	Ажилгүйдлийн даатгал	10,101,936.08	12,434,197.30
210205	Эрүүл мэндийн даатгал	38,194,099.36	49,700,675.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	516,384,791.38	571,391,268.36
210301	Гэрэл, цахилгаан	86,557,823.38	42,822,560.36
210302	Түлш, халаалт	377,109,138.00	454,480,628.00
210303	Цэвэр, бохир ус	52,717,830.00	74,088,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	67,012,559.01	50,399,955.00
210401	Бичиг хэрэг	23,643,210.00	12,983,185.00
210402	Тээвэр, шатахуун	32,294,751.01	20,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	9,256,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,074,598.00	8,160,570.00
2105	Нормативт зардал	126,872,720.00	188,879,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	832,920.00	1,036,400.00
210502	Хоол, хүнс	126,039,800.00	187,842,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,481,000.00	9,485,000.00
210604	Урсгал засвар	23,481,000.00	9,485,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,547,075.75	10,120,267.01
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,547,075.75	10,120,267.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	218,033,772.09	337,118,594.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,264,304.00	33,400,665.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	185,769,468.09	303,717,929.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,208,533.63	130,767,631.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,062,300.00	129,191,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,453,000.00	98,670,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,609,300.00	30,521,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,146,233.63	1,576,431.64
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,146,233.63	1,576,431.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	166,604,867.97	547,081,301.77
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	3,500,000.06
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	3,500,000.06
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	(3,500,000.06)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	166,604,867.97	543,581,301.71

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,110,879,000.00	3,735,500,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	30,006,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	30,006,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	30,006,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	30,006,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,110,879,000.00	3,705,494,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,559,916,100.00	3,138,329,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,559,916,100.00	3,138,329,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	550,962,900.00	567,165,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	550,962,900.00	567,165,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,079,445,670.03	3,827,797,376.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,079,445,670.03	3,827,797,376.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,980,237,136.40	3,699,953,545.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,912,580,999.71	2,479,067,630.11
210101	Үндсэн цалин	1,287,564,882.22	1,553,323,145.46
210102	Нэмэгдэл	524,636,217.49	721,598,355.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	9,460,000.00
210104	Урамшуулал	100,379,900.00	194,686,129.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	238,808,282.32	309,936,586.86
210201	Тэтгэврийн даатгал	161,631,577.96	210,781,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,394,200.00	24,797,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,697,000.00	12,399,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,697,000.00	12,399,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38,388,504.36	49,559,586.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	524,335,666.37	555,588,568.36
210301	Гэрэл, цахилгаан	36,739,904.37	42,822,560.36
210302	Түлш, халаалт	430,981,872.00	438,677,928.00
210303	Цэвэр, бохир ус	56,613,890.00	74,088,080.00
2105	Нормативт зардал	126,039,800.00	190,766,700.00
210502	Хоол, хүнс	126,039,800.00	190,766,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,481,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	23,481,000.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,308,800.00	26,958,567.01
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,308,800.00	26,958,567.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,682,588.00	127,635,492.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	108,016,688.00	116,928,792.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,665,900.00	10,706,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,208,533.63	127,843,831.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,062,300.00	126,267,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,453,000.00	95,746,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,609,300.00	30,521,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,146,233.63	1,576,431.64
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,146,233.63	1,576,431.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	31,433,329.97	(92,297,076.73)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	31,433,329.97	(92,297,076.73)

Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	65,875,431.99	97,308,761.96
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	97,308,761.96	5,011,685.23

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	528,890,398.74	528,890,398.74
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	528,890,398.74	528,890,398.74
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,340,462,137.97	6,340,462,137.97
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	7,033,031,965.49	7,033,031,965.49
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	7,033,031,965.49	7,033,031,965.49
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	543,581,301.71	543,581,301.71
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	7,576,613,267.20	7,576,613,267.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,341,633,900.00	3,260,632,376.73	81,001,523.27	97.58
Татварын бус орлого	3,341,633,900.00	3,260,632,376.73	81,001,523.27	97.58
Нийтлэг татварын бус орлого	137,314,500.00	122,303,376.73	15,011,123.27	89.07
Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	40,006,300.00	30,006,300.00	10,000,000.00	75.00
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	97,308,200.00	92,297,076.73	5,011,123.27	94.85
Тусламжийн орлого	3,204,319,400.00	3,138,329,000.00	65,990,400.00	97.94
Төсвөөс санхүүжих	3,204,319,400.00	3,138,329,000.00	65,990,400.00	97.94
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,341,633,900.00	3,260,632,376.73	81,001,523.27	97.58
УРСГАЛ ЗАРДАЛ	3,341,633,900.00	3,260,632,376.73	81,001,523.27	97.58
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,207,260,200.00	3,134,364,976.73	72,895,223.27	97.73
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,531,230,900.00	2,479,067,630.11	52,163,269.89	97.94
Үндсэн цалин	1,683,586,700.00	1,553,323,145.46	130,263,554.54	92.26
Нэмэгдэл	688,249,900.00	721,598,355.25	(33,348,455.25)	104.85
Унаа хоолны хөнгөлөлт	-	9,460,000.00	(9,460,000.00)	-
Урамшуулал	159,394,300.00	194,686,129.40	(35,291,829.40)	122.14
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	316,404,200.00	309,936,586.86	6,467,613.14	97.96
Тэтгэврийн даатгал	215,154,800.00	210,781,300.00	4,373,500.00	97.97
Тэтгэмжийн даатгал	25,312,300.00	24,797,600.00	514,700.00	97.97
ҮОМШӨ-ний даатгал	12,656,300.00	12,399,100.00	257,200.00	97.97
Ажилгүйдлийн даатгал	12,656,200.00	12,399,000.00	257,200.00	97.97
Эрүүл мэндийн даатгал	50,624,600.00	49,559,586.86	1,065,013.14	97.90
Нормативт зардал	190,766,700.00	190,766,700.00	-	100.00
Хоол, хүнс	190,766,700.00	190,766,700.00	-	100.00

Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,597,500.00	26,958,567.01	2,638,932.99	91.08
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	29,597,500.00	26,958,567.01	2,638,932.99	91.08
Бараа үйлчилгээний бусад зардал	139,260,900.00	127,635,492.75	11,625,407.25	91.65
Бараа үйлчилгээний бусад зардал	128,554,200.00	116,928,792.75	11,625,407.25	90.96
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,706,700.00	10,706,700.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	134,373,700.00	126,267,400.00	8,106,300.00	93.97
Бусад урсгал шилжүүлэг	134,373,700.00	126,267,400.00	8,106,300.00	93.97
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	103,852,500.00	95,746,200.00	8,106,300.00	92.19
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,521,200.00	30,521,200.00	-	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	97,308,761.96	(97,308,761.96)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,011,685.23	(5,011,685.23)	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	567,165,000.00	565,588,568.36	1,576,431.64	99.72
Татварын бус орлого	567,165,000.00	565,588,568.36	1,576,431.64	99.72
Тусламжийн орлого	567,165,000.00	565,588,568.36	1,576,431.64	99.72
Төсвөөс санхүүжих	567,165,000.00	565,588,568.36	1,576,431.64	99.72
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	567,165,000.00	565,588,568.36	1,576,431.64	99.72
УРСГАЛ ЗАРДАЛ	567,165,000.00	565,588,568.36	1,576,431.64	99.72
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	567,165,000.00	565,588,568.36	1,576,431.64	99.72
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	557,165,000.00	555,588,568.36	1,576,431.64	99.72
Гэрэл, цахилгаан	44,398,900.00	42,822,560.36	1,576,339.64	96.45
Түлш, халаалт	438,678,000.00	438,677,928.00	72.00	100.00
Цэвэр, бохир ус	74,088,100.00	74,088,080.00	20.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолбор нь “Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолбор нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу байгууллагын захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба бүтэц зохион байгуулалттай 90 орон тоотой, 624 суралцагчтай үйл ажиллагаа явуулжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

Тайлант онд Боловсролын Ерөнхий газар болон аймгийн Боловсролын газраас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолбор нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг"-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолбор нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 7,634,914.5 мянган төгрөг болж өмнөх оноос 533,028.2 мянган төгрөг өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	197,172.3	120,852.0	(76,320.24)
Мөнгөн хөрөнгө	97,308.8	5,011.7	(92,297.08)
Бараа материал	99,863.5	115,840.3	15,976.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,904,714.0	7,514,062.4	609,348.5
Үндсэн хөрөнгө	7,218,002.0	8,129,568.4	911,566.4
Хуримтлагдсан элэгдэл	(313,288.05)	(615,505.98)	(302,217.93)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,101,886.3	7,634,914.5	533,028.2
Өр төлбөр	68,854.3	58,301.2	(10,553.09)

Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Засгийн газрын хувь оролцоо	7,033,032.0	7,576,613.3	543,581.3
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,101,886.3	7,634,914.5	533,028.2

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 5,011.7 мянган төгрөг болж өмнөх оноос 92,297.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд өмнөх оны үлдэгдлээс зарцуулахаар батлагдаж зарцуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 115,840.3 мянган төгрөг болж өмнөх оноос 15,976.8 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд бараа материал төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 348,984.7 мянган төгрөгөөр, шилжүүлэн авсан 804,9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 338,178.1 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,129,568.4 мянган төгрөг болж өмнөх оноос 911,566.4 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 19,898.3 мянган төгрөгөөр, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 583 дугаар “Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор сургуулийн гадна орчны тохижилт засварын ажил барилгын сайжруулалт ангилалд 860,905.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 58,301.2 мянган төгрөг болж өмнөх оноос 10,553.1 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант оны төсвийн тодотголоор 8 хоногийн халаалтын төлбөрийг төсвийн хуваариас хасаж тодотгосонтой холбоотой 15,802.7 мянган төгрөгийн түлш халаалт, 84,997.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан ерөнхий гэрээгээр 2 жилийн хугацаанд хуваан төлөх нөхцөлтэй тайлант онд 21,240.0 мянган төгрөгийг төлж, үлдэгдэл 42,498.5 мянган төгрөгийн байгууллагад төлөх өр төлбөр үүссэн байна.

Тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ны Acolous accounting system 4.0 санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашигладаг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,365,274.4 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 630,995.9 мянган төгрөгөөр бууруулж, урьд оны үлдэгдлээс 97,308.2 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, 2,507,333.2 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотголоор 3,341,633.9 мянган төгрөгөөр тодотгожээ.

Орон нутгийн төсвөөс тогтмол зардалд 567,165.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр батлагджээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 3,341,633.9 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсоноос урсгал үйл ажиллагаанд 3,260,632.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	3,047.4	3,047.4	-	100.0
2	80233 Хүүхэд хамгаалал	3,133.8	2,937.1	196.7	93.7
3	80312 Сургалт семинар	1,678.5	1,678.5	-	100.0
4	81605 Эрүүл мэндийг дэмжих	3,212.4	3,212.4	-	100.0
5	81801 Үдийн цай хөтөлбөр	103,852.5	95,746.2	8,106.3	92.2
6	81806 Дотуур байрны үйлчилгээ	527,739.4	469,736.3	58,003.1	89.0
7	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	38,342.3	36,913.6	1,428.7	96.3
8	81823 Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	5,911.6	5,911.6	-	100.0
9	81834 Боловсролын стандарт, сургалты	2,386,865.0	2,384,849.1	2,015.9	99.9
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	218,079.6	217,454.2	625.4	99.7
11	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	5,006.3	5,006.3	-	100.0
12	81875 Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	9,765.1	9,139.7	625.4	93.6
13	83602 ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	35,000.0	25,000.0	10,000.0	71.4
	Нийт дүн	3,341,633.9	3,260,632.4	81,001.5	97.6

Орон нутгийн төсвөөс 567,165.0 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 565,588.6 мянган төгрөгийн зарцуулж, 1,576.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус байгууллага нь Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн "Багш ажилчдын 2025 онд ашиглах бүтэц, орон тоо, цалин, нэмэгдэл хөлсийг шинэчлэн тогтоох тухай" А/01 дугаар тушаалаар өдөрт хоолны 5.0 мянга, унааны 4.0 мянган төгрөгөөр буюу нийт 162,868.0 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлтийг олгосон байна.

Бүтэц орон тоог Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дугаар хамтарсан тушаалын хавсралт дахь "Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив"-д заасныг үндэслэн Баянхонгор аймгийн Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн захирал 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар 90 албан тушаалтны орон тоог баталж, төсвийн тодотголоор орон тоог бууруулаагүй, гүйцэтгэлээр 87 орон тоотой 2,479,067.6 мянган төгрөгийн цалингийн сантай, 3 орон тоо дутуу ажиллаж байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд үдийн цайны хүнсний нийлүүлэгч шалгаруулах 118,294.3 мянга, дотуур байрны хүүхдийн хоолны хүнсний нийлүүлэгч шалгаруулах 200,732.7 мянган төгрөгийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авалт хийхээр төлөвлөж, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар “Баян баялаг өргөө” ХХК-тай 97,996.8 мянган төгрөгийн үдийн цайны хүнсний материал нийлүүлэх, “Бага хонгил” ХХК-тай 166,798.0 мянган төгрөгөөр дотуур байрны хүүхдийн хоолны хүнсний материал нийлүүлэх гэрээг тус тус байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолбор нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Сонгосон суурь үзүүлэлт болох 2025 оны анхны батлагдсан төсөв 3,908,798.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 39,088.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 163 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан бөгөөд 3 мэдээллийг хугацаа хоцроосон шалтгаан нь 2025 оны төсөв хугацаандаа ирээгүй тул худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хоцроож, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,691,034.8 мянган төгрөгийн 80 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 791,547.1 мянган төгрөгийн 39 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 799,514.4 мянган төгрөгийн 13 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно аудит хийгээгүй.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг “Баян ташаагийн эх аудит” ХХК гүйцэтгэж, аудитаар 1,544.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгсөн ба тус байгууллагаас 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 80 дугаартай албан бичгээр аудитын шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлснийг хянаж үнэлсэн.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	1,544.0	1	1,544.0	100%
Нийт дүн	1	1,544.0	1	1,544.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд төсвийн тодотголоор 8 хоногийн халаалтын төлбөрийг төсвийн хуваариас хасаж тодотгосонтой холбоотой 15,802.7 мянган төгрөгийн түлш халаалт, 84,997.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан ерөнхий гэрээгээр 2 жилийн хугацаанд хуваан төлөх нөхцөлтэй тайлант онд 21,240.0 мянган төгрөгийг төлж, үлдэгдэл 42,498.5 мянган төгрөгийн байгууллагад төлөх өр төлбөр үүссэн байна. Дараагийн аудитаар тайлант оны өр төлбөрийг хэрхэн шийдвэрлэснийг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,825.3 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Бараа материалын тусгай зориулалтын дансанд 3,825.3 мянган төгрөгийн түрээсийн номны орлого аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 4 дүгээр зүйлийн 4.1.1, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн
Бараа материалын тусгай зориулалтын дансанд 3,825.3 мянган төгрөгийн түрээсийн номны орлого аваагүй байна.	1	3,825.3	1	3,825.3			1	3,825.3		
Дүн	1	3,825.3	1	3,825.3			1	3,825.3		

-----oOo-----

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.